



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 2 сарын 1-ний өдөр

То №1

Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах тухай

“Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.2 заалт, 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хавсралт 1-ээр баталсугай.
2. Компанийн бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 2 сарын 1-ний өдөр

То №2


Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 46.8 заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монгол Базальт” ХК –ийн дүрмийн 6.2.6.12 заалт, 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 /нэг/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар баталсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.
3. Ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн ҮЦГХТ дэх дансанд 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд компанийн мөнгөн урсгалын харгалзан ҮЦГХТ-тэй гэрээ байгуулан ногдол ашгийг тараасугай.
4. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигч нарт танилцуулсугай.
5. Ногдол ашиг хуваарилалтын тайланг МХБ, СЗХ-нд ажлын 10 хоног багтаан хүргүүлсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 2 сарын 1-ний өдөр

То № 3

Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшүүлэхээр зар хүргэх тухай

“Монгол Базалт” ХК-ийн 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базалт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвших сонирхол бүхий этгээдэд зарыг 2019 оны 2 дугаар сарын 19 – ний өдөр хүртэл компанин өөрийн цахим хуудсаар зарыг хүргэж, нэр дэвшигчдийн анкетыг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 17 цаг хүртэл хүлээн авахаар тогтсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД